

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/14/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Одбилэг

Утас: 70272287 Цахим хаяг: odbilegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл.....
 - 4.2 Материаллаг байдал.....
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
.....
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
.....
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГУМС	Засгийн газрын удирдлага мэдээллийн систем

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуушимод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

Танай 2024.03.28 -ны № 01/220 -г

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д.ХҮРЭЛБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 05 дугаар тогтоолоор 86,7 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэгдсэн байна. Сумын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 423,834.3 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 459,372.8 мянган төгрөг төвлөрүүлж 108,3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг дарга тайлант онд түүхт ойн бүтээн байгуулалтын жилийн хүрээнд иргэдийн санал санаачилгаар орон нутгийн хөгжлийн

G/Arkhir/Alban bichig 2024/ A4

010000580

сангийн хөрөнгөөр 494,200.0 мянган төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэж, данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

		/мянган төгрөгөөр/		
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022.12.31	2023.12.31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,433,480.8	1,465,058.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	905,058.9	638,643.6
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	377,554.6	668,875.5
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	150,867.3	157,539.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,480,068.0	2,277,403.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,480,068.0	2,277,403.7
39200	Биет хөрөнгө		1,476,852.0	2,274,187.7
39300	Биет бус хөрөнгө	13	3,216.0	3,216.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,913,548.8	3,742,462.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		11,358.8	28,351.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	11,358.8	28,351.9
41300	Өглөг	17а, 17б	11,358.8	28,351.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,902,190.0	3,714,110.4
51	Засгийн газрын хувь оролцоо		2,902,190.0	3,714,110.4
51100	Засгийн газрын оруулсан капитал		481,759.6	481,759.6
51200	Хуримтлагдсан үр дүн		2,117,902.8	2,929,823.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		302,527.6	302,527.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,913,548.8	3,742,462.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

		/мянган төгрөгөөр/		
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022.12.31	2023.12.31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,484,070.3	2,529,359.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО		229,910.6	451,215.1
110	Орлогын албан татвар		184,285.1	282,480.9
1100	Хувь хүний орлогын албан татвар		189,976.5	290,638.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-5,691.3	-8,157.2
113	Хөрөнгийн албан татвар		27,867.5	41,984.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж		17,757.9	126,749.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	509,224.4	770,554.5
120	Нийтлэг татварын бус орлого		509,224.4	770,554.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,744,935.3	1,307,589.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,958,978.2	1,348,194.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,756,359.2	1,221,302.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		904,102.4	1,216,012.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		292,992.3	450,730.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		34,682.5	53,824.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		248,615.2	45,941.2
2104	Хангамж, бараа материалын зардал		64,894.3	55,991.3
2105	Нормативт зардал		29,488.7	17,570.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		12,080.3	21,205.3
2107	Томилолт, зочны зардал		6,208.1	5,772.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		29,873.1	54,843.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		185,268.0	510,133.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		852,256.8	5,290.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		202,619.1	126,892.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		525,092.1	1,181,164.5

IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	427.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		4,247,873.7	369,671.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-3,722,781.7	811,920.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,705,108.9	0.0	6,705,108.9
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,902,190.0	0.0	2,902,190.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,624,971.7	0.0	6,624,971.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-80,137.2	0.0	-80,137.2
9	Тайлант үеийн үр дүн	-3,722,781.7	0.0	-3,722,781.7
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,902,190.0	0.0	2,902,190.0
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,714,110.4	0.0	3,714,110.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,902,190.0	0.0	2,902,190.0
19	Тайлант үеийн үр дүн	811,920.4	0.0	811,920.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022.12.31	2023.12.31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		2,253,671.4	1,955,971.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО		229,910.6	459,372.3
110	Орлогын албан татвар		184,285.1	290,638.1
1100	Хувь хүний орлогын албан татвар		189,976.5	290,638.1
113	Хөрөнгийн албан татвар		27,867.5	41,984.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж		17,757.9	126,749.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		2,622.6	4,519.7
1181	Газрын төлбөр		13,135.4	17,830.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		2,000.0	104,400.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		280,784.1	198,509.6
120	Нийтлэг татварын бус орлого		280,784.1	191,009.6
122	Тусламжийн орлого		0.0	7,500.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,742,976.7	1,298,089.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,681,421.5	1,286,456.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,681,421.5	1,286,456.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		799,201.1	1,283,516.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		292,992.3	452,567.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		34,682.5	55,205.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		248,615.2	45,941.2
2104	Хангамж, бараа материалын зардал		28,828.4	27,336.6
2105	Нормативт зардал		29,627.7	1,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		13,869.4	6,300.0
2107	Томилот, зочны зардал		4,674.1	5,613.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		32,936.5	44,349.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		112,975.0	645,203.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		882,220.4	2,940.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		572,249.9	669,514.7

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		381,955.0	901,330.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		381,955.0	901,330.0
2200	Дотоод эх үүсвэрээр		381,955.0	901,330.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-381,955.0	-901,330.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-99,365.4	-34,600.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		99,365.4	34,600.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		90,929.4	-266,415.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		814,129.4	905,058.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		905,058.9	638,643.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,453,009.9	1,920,132.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,108,029.8	984,202.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,105,029.8	981,262.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	450,144.9	432,474.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,268.1	53,175.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	310,291.8	286,065.6
2104	Хангамж, бараа материалын зардал	25,951.8	25,732.0
2105	Нормативт зардал	1,000.0	1,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,450.0	10,168.5
2107	Томилолт, зочны зардал	5,687.0	5,613.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,498.4	43,209.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	195,737.8	123,824.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000.0	2,940.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000.0	2,940.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,242,980.1	901,330.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	102,000.0	34,600.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,453,009.9	1,542,250.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	367,727.0	358,521.4
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,116,708.4	1,132,424.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	918,574.5	43,805.1
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	50,000.0	7,500.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	673,862.8
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	295,981.1
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	58	46
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28	22
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28	22

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	190,787.1	304,896.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	90,787.1	304,896.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,432.5	283,868.0

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.0	20,093.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	2,030.4
2104	Хангамж, бараа материалын зардал	2,976.6	1,604.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300.0	1,140.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,155.9	259,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,354.6	21,028.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,832.2	0.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,522.4	21,028.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	100,000.0	0.0
2200	Дотоод эх үүсвэрээр	100,000.0	0.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	188,289.2	304,896.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	188,289.2	304,896.9
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-2,497.9	0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,497.9	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг дарга нь орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг дарга төрийн хуулийг дээдлэн хүндэлж иргэдэд төрийн үйлчилгээг тасралтгүй, ил тод, нээлттэй хүргэн ард иргэдийнхээ амьжиргааны түвшин дээшлүүлэх замаар сум орон нутгаа хөгжүүлэхэд оршино гэсэн зорилт тавин ажилласан байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг дарга тайлант онд түүхт ойн бүтээн байгуулалтын жилийн хүрээнд иргэдийн санал санаачилгаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 494,200.0 мянган төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал сумын төвийн айл өрхүүдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажилд 215,000.0 мянган төгрөг, Өлзийт нуурт амрагчдын байр шинээр барих ажилд 17,054.5 мянган төгрөг, багийн төвийн барилгын засварын ажилд 5,800.0 мянган төгрөг, 4 ш гүн өрмийн худаг 40,000.0 мянган төгрөг, ЗДТГ-ын барилгын гадна пасад, хүзүүвч барилгын засварт 95,352.0 мянган төгрөгийн ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 05 дугаар тогтоолоор 86,7 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг дарга төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 4, 8, 10, 12, 23, 24, 28, 30 дугаар зүйл,
- Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар бүлэг, 4, 11, 13, 20, 41, 57, 59, 66 дугаар зүйл,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3, 8, 46 дугаар зүйл

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн "Дотоод хяналтын зөвлөл шинэчлэн батлах тухай" А/193 захирамжаар томилж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын дотоод хяналтын зөвлөл нь тайлант онд дотоод хяналт шалгалтыг улирлаар төлөвлөн хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг дарга 2021 онд батлагдсан 5 бүлэг бүхий Төв аймгийн төсвийн байгууллага, төсөл сангуудын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 828,913.5 мянган төгрөгөөр буюу 28,5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	905,058.9	638,643.6	-266,415.3
Авлага	377,554.6	668,875.5	291,320.9
Бараа материал	150,867.3	157,539.6	6,672.3
Үндсэн хөрөнгө	1,480,068.0	2,277,403.7	797,335.7
Нийт хөрөнгө	2,913,548.8	3,742,462.3	828,913.5
Өр төлбөр	11,358.8	28,351.9	16,993.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,902,190.0	3,714,110.4	811,920.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,913,548.8	3,742,462.3	828,913.5

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 266,415.3 мянган төгрөгөөр буурч 638,643.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Тайлант онд орон нутгийн орлого 318,473.4 мянган төгрөг нь давсан орлогын үлдэгдэл, орон нутгийн хөгжлийн сан 233,082.3 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын хийгдээгүй ажлын үлдэгдэл, хоршоо хөгжүүлэх сангийн 62,898.8 мянган төгрөгийн үлдэгдэл, Эмийн эргэлтийн сангийн 14,049.1 мянган төгрөг, 10,140.0 мянган төгрөгийн Байгаль хамгаалах барьцаа нөхөн сэргээлтийн сангийн үлдэгдэл тус тус нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 668,875.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 291,320.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засаг даргын Тамгын газар 1,750.4 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 230,590.5 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 434,982.2 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 1,530.4 мянган төгрөгийн авлага үүссэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 157,539.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,672.3 мянган төгрөгөөр өссөн нь Засаг даргын Тамгын газар 3,120.2 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 1,604.8 мянган төгрөгөөр, Эмийн эргэлтийн сан 1,947.2 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,277,403.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 797,335.7 мянган төгрөгөөр өссөн нь Засаг даргын Тамгын газар 785,757.7 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 11,578.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй болон худалдан авснаас шалтгаалсан байна.

Тайлант онд өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 28,351.9 мянган төгрөг болж 16,993.1 мянган төгрөгөөр өсчээ. Засаг даргын Тамгын газарт 3,467.1 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 1,790.8 мянган төгрөг, Иргэдийн төлөөлөгчдийн Хурал 28.0 мянган төгрөгийн өглөг шинээр үүсгэж, Орон нутгийн хөгжлийн сан 3,550.0 мянган төгрөг, Орон нутгийн ерөнхий орлого 8,157.2 мянган төгрөгийн өглөг оны эхнээс нэмэгдүүлсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 3,714,110.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 811,920.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 247,963.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 61,070.1 мянган төгрөгөөр буюу 32,7 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	211.1	0.0	-211.1
Банканд байгаа бэлэн мөнгө	904,847.7	638,643.6	-266,204.1
Төгрөг	904,847.7	638,643.6	-266,204.1
Төрийн сангийн харилцах	900,456.8	624,594.5	-275,862.3
Арилжааны банк дахь харилцах	4,390.9	14,049.1	9,658.2
Дүн	905,058.8	638,643.6	-266,415.2

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн мөнгөн хөрөнгийн тодруулга

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 638,643.6 мянган төгрөг нь төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 624,594.5 мянган төгрөг, арилжааны банкны дансанд 14,049.1 мянган төгрөг байршиж байна. Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 638,643.6 мянган төгрөгийн 49,9 хувь буюу орон нутгийн ерөнхий орлогын 318,473.4 мянган төгрөг, 36,5 хувь буюу Орон нутгийн хөгжлийн сангийн 233,082.3 мянган төгрөг, 9,8 хувь буюу Хоршоо хөгжүүлэх сангийн 62,898.8 мянган төгрөг, 1,6 хувь буюу Байгаль хамгаалах барьцаа нөхөн сэргээлтийн сангийн 10,140.0 мянган төгрөг, 9.8 хувь буюу Эмийн эргэлтийн сангийн 14,049.1 мянган төгрөгийн үлдэгдэл байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 275,862.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оноос Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 386,092.3 мянган төгрөгөөр буурч, Хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 8,210.6 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 100,019.4 мянган төгрөг, Байгаль хамгаалах сан 2,000.0 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Арилжааны банк дахь харилцах данс буюу эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 9,447.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын илрүүлэлт

1. Төв аймгийн Баянцагаан сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2023 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн Б/02 тоот “Цалин шинэчлэн тогтоох тухай” захирамжаар улс төрийн албан хаагчийн орон нутгийн нэмэгдэлд 1,518.3 мянган төгрөг олгосон зөрчилд төлбөрийн акт бичив.
2. Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчин иргэн, айл өрхүүдэд бараа үйлчилгээний бусад зардлаас цаг тооны бичиг, сахар, будаа зэрэг зүйлсийг бэлтгэж, тараан олгосон зөрчил илэрч албан шаардлага тогтоож ажиллав.
3. Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн уялдааг тулгаж үзэхэд мөнгөн гүйлгээний тайланг 29,337.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдааг залруулав.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 668,875.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 291,320.8 мянган төгрөгөөр буюу 77,1 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	0.0	0.0	0.0
Байгууллагаас авах авлага	146,336.3	436,754.6	290,418.3
Хувь хүмүүсээс авах авлага	231,218.4	232,120.9	902.5
Дүн	377,554.7	668,875.5	291,320.8

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн авлагын тодруулга

Авлагын үлдэгдэлд Хоршоо хөгжүүлэх сангийн 230,590.5 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага 34,5 хувийг, Засаг даргын Тамгын газрын авлага 1,750.4 мянган төгрөг буюу 0,3 хувийг, Орон нутгийн хөгжлийн сангийн авлага 434,982.2 мянган төгрөг буюу 64,2 хувийг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын авлага 22.0 мянган төгрөг буюу 0,1 хувийг, Эмийн эргэлтийн сангийн авлага 3,229.0 мянган төгрөг буюу 0,9 хувийг эзэлж байна. Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 668,875.5 мянган төгрөгийн 65,3 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 34,7 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: Засаг даргын Тамгын газар нь санхүүгийн программны үнэ болох 1,750.0 мянган төгрөгийг авлагыг бүртгээгүй байсныг залруулж авлагаар тусгасан.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 157,539.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,672.0 мянган төгрөгөөр буюу 104,4 хувиар өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Түүхий эд материал	13,287.2	15,234.4	1,947.2
Тусгай зориулалттай материал	0.0	0.0	0.0
Эм боох материал	13,287.2	15,234.4	1,947.2

Хангамжийн материал	105,175.2	109,900.2	4,725.0
Бичиг хэргийн материал	5,966.5	5,464.1	-502.4
Аж ахуйн материал	79,772.6	91,513.9	11,741.3
Сэлбэг хэрэгсэл	8,068.5	120.0	-7,948.5
Барилгын засварын материал	0.0	0.0	0.0
Хүнсний материал	0.0	0.0	0.0
Бусад хангамжийн материал	11,367.6	12,802.2	1,434.6
Мал амьтад	32,405.0	32,405.0	0.0
Дүн	150,867.4	157,539.6	6,672.2

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн бараа материалын тодруулга

Бараа материалын үлдэгдэл 157,539.6 мянган төгрөгийн 87,0 хувь буюу 137,104.4 мянган төгрөгийг Засаг даргын Тамгын газар, 3,4 хувийг буюу 5,380.7 мянган төгрөгийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, 9,6 хувийг буюу 15,054.4 мянган төгрөгийг Эмийн эргэлтийн сангийн бараа материал эзэлж байна. Бараа материал данс худалдан авсан 178,970.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 172,298.6 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт: Бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн хандиваар болон шилжүүлэн авсан дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан дүнтэй тулгахад 28,110.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдааг залруулсан..

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,277,403.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 797,335.7 мянган төгрөгөөр буюу 53,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Биет хөрөнгө	1,476,852.0	2,274,187.7	797,335.7
Барилга, байгууламж, орон сууц	918,366.7	1,320,072.6	401,705.9
Авто-тээврийн хэрэгсэл	54,669.9	225,903.9	171,234.0
Машин тоног төхөөрөмж (компьютер)	63,978.1	96,705.0	32,726.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	26,323.2	42,117.3	15,794.1
Бусад үндсэн хөрөнгө	413,514.1	589,388.9	175,874.8
Биет бус хөрөнгө	3,216.0	3,216.0	0.0
Программ хангамж	882.0	882.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	2,334.0	2,334.0	0.0
Дүн	1,480,068.0	2,277,403.7	797,335.7

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үндсэн хөрөнгийн тодруулга

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 99,4 хувь буюу 2,263,141.6 мянган төгрөгийг сумын Засаг даргын Тамгын газар, 14,130.1 мянган төгрөг буюу 0.6 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн Хурал эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 2,277,403.7 мянган төгрөг болж, худалдаж авсан 129,862.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй авсан 794,869.1 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, 58,561.9 мянган төгрөгийн хөрөнгө акталж устгасан байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар илэрсэн алдаа зөрчил гараагүй болно.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 4,449.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,981.1 мянган төгрөгөөр буюу 35,6 хувиар буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	3,467.1	3,467.1
Байгууллагад төлөх өглөг	6,458.8	16,406.8	9,948.0
Хувь хүмүүст төлөх өглөг	4,900.0	8,478.0	3,578.0
Дүн	11,358.8	28,351.9	16,993.1

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн өглөгийн тодруулга

Богино хугацаат өр төлбөрийн хувьд Засаг даргын тамгын газар 3,467.1 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 1,790.8 мянган төгрөг, Орон нутгийн ерөнхий орлогын данс ХХОАТ-ын буцаалт болох 8,157.2 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 3,550.0 мянган төгрөгөөр оны эхнээс нэмэгдүүлж, Байгаль хамгаалах сан, Хоршоо хөгжүүлэх сан тус бүр 500.0 мянган төгрөгийн оны эхний өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил байхгүй.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,714,110.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 811,920.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	481,759.6	481,759.6	0.0
Хуримтлагдсан үр дүн	2,117,902.8	2,929,823.2	811,920.4
Өмнөх үеийн үр дүн	8,896,110.2	4,728,854.3	-
Тайлант үеийн үр дүн	-4,166,399.7	129,040.8	4,295,440.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	302,527.6	302,527.6	0.0
Дүн	5,662,147.2	5,823,943.0	161,795.8

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,714,110.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 811,920.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Баянцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолд зааснаар тайлант онд 423,834.30 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 655,695.5 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 367,727.0 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл 619,174.5 мянган төгрөгөөр, сумын шилжих үлдэгдлийг 197,400.0 мянган төгрөгөөр, хандив тусламжийн орлогыг 50,000.0 мянган төгрөгөөр, нийт 2,313,831.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 9. Орлого эх үүсвэрийн үзүүлэлтүүд

/ мянган төгрөгөөр/

Орлого, эх үүсвэрийн үзүүлэлтүүд	Төсөв баталсан ИТХ-ын тогтоол		Нэмэгдсэн зөрүү
	2022.12.19 №02	2023.08.28 №01	
Татварын орлого	381,153.50	405,434.30	24,280.80
Татварын бус орлого	28,278.00	18,400.00	-9,878.00
Татварын болон татварын бус орлогын дүн	409,431.50	423,834.30	14,402.80
Сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	588,851.20	655,695.50	66,844.30
Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	283,054.50	367,727.00	84,672.50
Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл	619,174.50	619,174.50	0.00
Шилжих үлдэгдэл	197,400.00	197,400.00	0.00
Сумын 100 жилийн хандив тусламжийн эх үүсвэр	50,000.00	50,000.00	0.00
Эх үүсвэрийн нийт дүн	2,147,911.70	2,313,831.30	165,919.60

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналаас Баянцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн 02 дугаар тогтоолд зааснаар Баянцагаан сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 423,834.3 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тодотгон баталж, гүйцэтгэлээр 459,372.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 103,7 хувиар биелүүлсэн байна.

Тайлант онд орон нутагт төвлөрүүлэх орлогоос нэр төрлийн хувьд 36,225.1 мянган төгрөгөөр малын тоо толгойд ногдуулах албан татварын орлого, 3,370.0 мянган төгрөгөөр хөрөнгө борлуулсаны орлого 1,970.0 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 10,447.6 мянган төгрөгөөр, нийт 52,012.7 мянган төгрөгөөр тасарсан байна. ХХОАТ-ын буцаалт болох 8,157.1 мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлээгүй орон нутгийн ерөнхий орлогын дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Засаг даргын үйл ажиллагааны зардлыг 91,031.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 866,359.0 мянган төгрөгөөр тодотгон, баталсан байна.

Хүснэгт 10. Орлого эх үүсвэрийн үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

Орлого, эх үүсвэрийн үзүүлэлтүүд	Төлөвлөгөө		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Татварын орлого	405,434.3	358,912.2	(46,522.1)
Татварын бус орлого	18,400.0	100,460.0	82,060.0
Татварын болон татварын бус орлогын дүн	423,834.3	459,372.2	35,537.9
Сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	655,695.5	655,695.5	-
Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	367,727.0	358,521.4	(9,205.6)
Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл	619,174.5	619,174.5	-
Шилжих үлдэгдэл	197,400.0	76,700.0	(120,700.0)
Сумын 100 жилийн хандив тусламжийн эх үүсвэр	50,000.0	-	(50,000.0)
Хоршоо хөгжүүлэх сан	102,000.0	34,600.0	(67,400.0)
Эх үүсвэрийн нийт дүн	2,415,831.3	2,169,463.6	(246,367.7)

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 461,012.9 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 655,695.5 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 367,727.0 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл 619,174.5 мянган төгрөгөөр, сумын шилжих үлдэгдлийг 197,400.0 мянган төгрөгөөр, нийт 2,351,009.9 мянган төгрөгөөр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 655,695.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,920,132.4 мянган төгрөг буюу 78,2 хувьтай байна. Хэмнэгдсэн зардлын 23,2 хувь буюу 123,827.3 мянган төгрөгөөр үндсэн үйл ажиллагааны урсгал зардал, 64,1 хувь буюу 341,650.0 мянган төгрөгөөр хөрөнгийн зардал буюу Орон нутгийн хөгжлийн сангаас хийгдэх ажлын гүйцэтгэл гараагүй зардал, 12,6 хувь буюу 67,400.0 мянган төгрөгөөр Хоршоо хөгжүүлэх сангийн зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	130,747.2	129,004.9	1,742.3	98.7
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	866,359.1	741,067.3	125,291.8	85.5
3	Ерөнхий боловсролын сургууль	170,961.1	164,806.9	6,154.2	96.4
4	Сургуулийн өмнөх боловсрол	30,535.0	28,852.5	1,682.5	94.5
5	Соёлын үйлчилгээ	27,331.6	23,111.6	4,220.0	84.6
6	Эрүүл мэндийн төв	32,595.8	27,222.0	5,373.8	83.5
7	Хоршоо хөгжүүлэх сан	102,000.0	34,600.0	67,400.0	33.9
8	Орон нутгийн хөгжлийн сан	1,092,480.1	771,467.2	321,012.9	70.6
	Дүн	2,453,009.9	1,920,132.4	532,877.5	78.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны захирагчаас 256,941.1 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 47,955.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг дарга тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 283,868.0 мянган төгрөг зарцуулж, Засаг даргын тамгын газар 20,439.2 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 589.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 9 хөтөлбөрийн 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 4. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023.01.01 2023.12.31	ИТХ-ын төлөөлөгч, ажлын албан хороодод үзүүлэх үйлчилгээ	Сумын ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгчид бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хурлын үйл ажиллагааг тасралтгүй мэдээллээр ханган хэвийн үйл ажиллагааг ханган явуулсан байна. Хэрэгжилт 100%	130,747.2	104,049.4
2	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01 2023.12.31	Гүйцэтгэх засаглалын удирдлага, ажлын алба түүний	Төрийн бодлого шийдвэр хууль тогтоомжийг хэрэгжүүлэн сурталчлан таниулах үйл ажиллагааг явуулж төрийн албаны үйлчилгээг цаг алдалгүй иргэдэд хүргэж, иргэд, удирдлагуудыг мэдээллээр шуурхай үйлчилж ажилласан байна. Хэрэгжилт 95,6%	866,359.1	656,584.28
3	70106 Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01 2023.12.31	Хоршооны үйл ажиллагааг дэмжин ажиллах	Төсөл сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулан 1 хоршоо, 5 иргэнд зээл олгон ажилласан байна. Хэрэгжилт 33.9%	102,000.0	34,600.0
4	71802 Ерөнхий боловсролын сургууль	2023.01.01 2023.12.31	Сурагчдын сурч боловсрох таатай орчин бүрдүүлэн ажиллана.	Хэрэгжилт 100%	170,961.1	106,933.23
5	71801 Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01 2023.12.31	БШУЯ-наас гаргасан чиглэлийн дагуу хүүхдийг зайны сургалтад 94%-тай хамруулан агуулгын хоцрогдлыг нөхөн ажиллана.	Мөн багшийн хөгжилд анхааран сургалт зөвлөгөөнд хамруулан ажиллаж боловсролын үнэлгээгээр 98%	30,535.0	41,354.51
6	71702 Соёлын үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Соёл урлагийн олон талт үйл ажиллагаа болон нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах	Соёл урлагийн олон талт үйл ажиллагааг сурталчлах ажлыг 3 удаа зохион байгуулан, хэрэгжилт	27,331.6	17,836.32
7	71602 Эрүүл мэндийн төв	2023.01.01 2023.12.31	Хэрэгжүүлж байгаа 9 хөтөлбөр, 3 бодлогын хүрээнд НЭМ-ийн тусламж үйлчилгээ үзүүлж сургалт сурталчилгаа хийнэ.	хэрэгжилт 100%-тай байна.	32,595.8	37,930.98

8	70106 Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01 2023.12.31	Сумын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд ажиллагааг хэрэгжүүлэх үйл	ОНХСангийн төсөл хөтөлбөрөөр 8 хөрөнгө оруулалтын ажил, 2 хөтөлбөр хэрэгжин ажилласан байна.	1,092,480.1	515,825.24
---	------------------------------------	--------------------------	---	--	-------------	------------

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 533,595.8 мянган төгрөгийг, урсгал төсвийн хөрөнгөөр 170,778.7 мянган төгрөгийг, нийт 704,374.5 мянган төгрөгийг зарцуулахаар 34 арга хэмжээг төлөвлөсөн байна. Тухайлбал: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Сумын төвийн айл өрхүүдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох” ажилд нээлттэй тендер шалгаруулж Мөнхчандмань Илч ХХК 205,676.2 мянган төгрөгөөр, тендер шалгаруулалтын онцгой журмаар ЗДТГ-ын гадна засвар, хүзүүвч барилгын их засварын ажил Лантмон ХХК 94,959.10 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын авто машины шинэчлэл 63,900.0 мянган төгрөгөөр тус төсөвт өртөгтөө багтаан хийж гүйцэтгэсэн байна. Эдгээр ажлуудыг худалдан авах ажиллагааны журмын дагуу зохион байгуулж хөрөнгө, материалыг данс бүртгэлд тусгаж ажилласан байна. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас автомашины граж 28,000.0 мянган төгрөг, мал угаах ванн 20,000.0 мянган төгрөг, арьс шир боловсруулах цех барих 9,000.0 мянган төгрөг, 15,000.0 мянган төгрөгийн наадмын асрыг засварлах зэрэг ажлууд хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн данстай холбоотой өгөгдсөн зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одбилэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 11-ны өдрийн 01/90 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,631,158.0 мянган төгрөгийн суурь үзүүлэлтээс материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар 24,467.3 мянган төгрөгөөр тогтоож баримтжууллаа. Мөн санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 18,350.52 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг дарга тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,920,132.4 мянган төгрөг буюу 78,3 хувьтай байна. Хэмнэгдсэн зардлын 23,2 хувь буюу 123,827.3 мянган төгрөгөөр үндсэн үйл ажиллагааны урсгал зардал, 64,1 хувь буюу 341,650.0 мянган төгрөгөөр хөрөнгийн зардал буюу Орон нутгийн хөгжлийн сангаас хийгдэх ажлын гүйцэтгэл гараагүй зардал, 12,6 хувь буюу 67,400.0 мянган төгрөгөөр Хоршоо хөгжүүлэх сангийн зардал тус тус эзэлж байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 178 мэдээлэл байршуулахаас 136 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 42 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна. Мөн урд оны санхүүгийн тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажлаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой 2 зөвлөмж, шилэн данстай холбоотой 1 зөвлөмж нийт 3 зөвлөмж өгөгдсөнийг 66,6 хувьтай хэрэгжүүлэн Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 05/57 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	3	23,308.4	2	23,308.4	66.6
Нийт дүн	3	23,308.4	2	23,308.4	66.6

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянцагаан сумын “Түүхт 100 жилийн ой 2024 онд тохиож байгаатай холбогдуулан иргэд, аж ахуй нэгж байгууллагаас өгсөн хандив тусламжийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагнал, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд иргэд олон нийтийн саналыг тусгаж эрэмбэлсэн эсэх, гүйцэтгэл, тендер шалгаруулалтай холбоотой асуудлуудыг анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 63,177.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 3,007.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 60,169.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Аудитаар Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд орон нутгийн нэмэгдэл олгохоор батлагдсан цалингийн зардлаас зарцуулагдаагүй үлдэгдэл 3,007,539.42 төгрөгийг аймгийн нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2-д “Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт бичив.

5.2 Албан шаардлага

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 411,125.6 мянган төгрөг, гүйцэтгэлээр 459,372.2 мянган төгрөг төвлөрсөн ба 16 нэр төрлийн орлогоос 5 нэр төрлийн орлого нийт 52,012.7 мянган төгрөгөөр тасарсан, ХХОАТ-ын буцаалт болох 8,157.1 мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлээгүй орон нутгийн ерөнхий орлогын дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт:

1. Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр ЗГУМС-тэй тулган баталгаажуулахгүй өр, авлагыг бүрэн тусгаж мэдээлэхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д “Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил бүтэн жилээр бэлтгэ тайлагнана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр Төрийн сангийн төлбөр тооцооны журмын дагуу холбогдох маягтаар гаргуулан авч хянан баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” заалтын дагуу ирүүлж, зөвлөмж болон албан шаардлагын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарла лттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзса	
A	1	2	3	4	5					7
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1						
2	Засаг даргын тамгын газар	1	1				1			
3	Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан	1		1						
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1						
5	Эмийн эргэлтийн сан	1		1						
6	Орон нутгийн хөгжлийн сан	1		1						
	НИЙТ	6	1	5			1			

7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	533.20			1	533.20	1	533.20		
Засаг даргын Тамгын газар	3	61,437.60			3	61,437.60	2	57,447.30	1	3990.3
Дүн	4	61,970.8	0.0	0.0	4.0	61,970.8	3.0	57,980.5	1.0	3,990.3

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	4	63,177.3	1	3007.5	2	60,169.8	1	0.00
Засаг даргын Тамгын газар	3	1,171,178.8	1	13,029.8	1	1,157,213	1	936.4
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	4	132,498.2	1	1,518.8	3	130,979.40	-	-
Хоршоо хөгжүүлэх сан	1	230,797	-	-	1	230,797	-	-
Дүн	12	1,597,651.2	3	17,556.10	7	1,579,158.7	2	936.40

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn